



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/135

Мандалговь

“Чугдаа Жин” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/180 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц” ажлын батлагдсан зардлаас Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор Шуурхай штабын дотор үйлчилгээнд автомашин нийлүүлэх ажлыг “Чугдаа жин” ХХК-тай 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор Шуурхай штабын дотор үйлчилгээнд автомашин нийлүүлэх ажлыг “Чугдаа жин” ХХК-ны захирал (Б.Чулуунбаатар)-т үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Онцгой байдлын газрын дарга (М.Адъяабаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210577